



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Цахим Фитнесс төслийг хэрэгжүүлэхэд
зардал гаргах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.7, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 онд гарсан Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, Цахим Фитнесс төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Биеийн тамир, спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төв, Техник спортын төв, Булган аймгийн Хангал сумын Спорт бэлтгэлийн төвд Ухаалаг дэлгэцийг худалдан авч нийлүүлэх ажлыг зохион байгуулж явуулахыг Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс /О.Баасан/-д даалгасугай.

2. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, аймаг, нийслэл, дүүрэг харьяа байгууллагыг гуравдугаар төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Тоног төхөөрөмж худалдан авах зориулалттай 13 120 000 сая төгрөгийг аймаг, нийслэл, дүүрэг, харьяа байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэхийг Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс /Э.Адъяасүрэн/-д даалгасугай.

4. Шаардагдах зардалд 459 200 000 /Дөрвөн зуун тавин есөн сая хоёр зуун мянган/ төгрөгийг Нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Ариунсанаа /-д зөвшөөрсүгэй.

5. Тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан үр дүнг тайлагнахыг Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс /Э.Адъяасүрэн/-д даалгасугай

6. Төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Одбаатар/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

000000246


Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир,
спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 18 ны
өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БЭЛТГЭЛ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх ажлын агуулга, арга зам	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төслийн үндсэн суурь судалааг гаргах судалгаа хийх	XII/07-08	БТБХХэлтэс
2	2020 онд гарсан Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг орчуулах	XI- XII	БТБХХэлтэс
3	Төсөлтэй холбоотой мэдээлэл, холбогдох материалуудыг боловсруулах, төсөл танилцуулах	XII/07-11	БТБХХэлтэс
4	Цахим фетнисс төслийг даргын зөвлөлийн хуралд танилцуулах санал авах	XII/14, 16	О.Баасан
5	Даргын зөвлөлөөс гарсан санал, зөвлөмжийг төсөлд тусгах	XII/17	О.Баасан
6	Төсөлтэй холбоотой Ухаалаг дэлгэц худалдан авах үнийн судалгааг холбогдох байгууллагаас авах	XII/14-18	БТБХХэлтэс
7	Ухаалаг дэлгэц худалдан авах үнийн судалгааг танилцуулах	XII/18	О.Баасан
8	Холбогдох тушаал, гэрээ, албан бичиг боловсруулж гаргах	XII/25-30	БТБХХэлтэс
9	21 аймаг, нийслэл, дүүргийн удирдлагуудтай холбогдох, чиглэл өгөх	XII/25-30	БТБХХэлтэс
10	21 аймаг, нийслэл, дүүрэгт Ухаалаг дэлгэцийг хүргэх ажилд хяналт тавих	XII/25-30	ХШҮДАХэлтэс
11	21 аймаг, нийслэл, дүүрэгт Ухаалаг дэлгэцийг ашиглах талаар сургалт зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх	2021 оны I сард	БТСУХороо
12	Цахим хурал хийх ажлыг зохион байгуулах	2021 он	БТСУХороо
13	Төрийн бус байгууллагатай хамтран иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх ажлыг зохион байгуулах	2021 он	БТБХХэлтэс
14	Аймаг орон нутгын онцлогт тохирсон биеийн тамирын арга хэмжээг цахимаар зохион байгуулах, дасгал хөдөлгөөн хийх, зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт тавих	2021 он	БТБХХэлтэс
15	Сар бүр, цахим сургалтыг зохион байгуулах, жилийн эцэст тайлан мэдээг нэгтгэн үр дүнг даргын зөвлөлийн хуралд танилцуулах	2021 он	О.Баасан

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир,
спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 18 ны
өдрийн 199 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЦАХИМ ФИТНЕСС ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
НЭГДСЭН ЗААВАР

Нэг. Зорилго.

Монгол Улсын 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаа урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Ерөнхийлөгчийн 2010 оны “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх тухай” 53 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоол, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх, цар тахлаас урьдчилан сэргийлэх иргэдийн эрүүл мэнд, биеийн дархлааг дэмжих ажлыг цахимаар улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг хангахад оршино.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт, хугацаа

Арга хэмжээг улсын хэмжээнд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, аймаг орон нутгийн Биеийн тамир, спортын хороо, харъяа байгууллагууд удирдан зохион байгуулж явуулна. Хэрэгжих хугацаа 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 12 сарын 31-нийг хүртэл зохион байгуулна.

Гурав. Ухаалаг самбар ашиглан дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

Аймаг, орон нутгийн иргэдийн дунд өглөө, оройны дасгалыг өвлийн цагт зааланд байрлуулж лайв хийх байдлаар ашиглах ба аюулгүй байдал, ашиглах зааврын дагуу хэрэглэж хэвших

- Цахим хурал, сургалтыг иргэдийн дунд зохион байгуулж хөдөлгөөний зөвлөмж, аргачлалыг хүргэх
- Онлайн уулзалтуудыг зохион байгуулах, шинийг төлөвлөх, санаачлах, багаар ажиллах чадварт суралцахад ашиглах
- Тухайн орон нутгийн иргэдийг биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнд өргөнөөр татан оролцуулах, биеийн тамир, спортод хандах хандлагыг өөрчлөх, идэвх сонирхлыг өрнүүлэх, бие даан хичээллүүлэх эрмэлзлийг төрүүлэх,
- Иргэдийн эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамтарч ажиллах
- Аж ахуй нэгж байгууллагыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжих, эрчимжүүлэх.
- Тэмцээн уралдааны дүн мэдээг оруулах, тайлагнах ажилд ашиглах

Дөрөв. Тайлагналт


Ухаалаг дэлгэц ашиглан иргэд, аж ахуй нэгж байгууллагын дунд зохион байгуулсан арга хэмжээ, өглөө, оройны дасгал, цахим хурал, сургалт зохион байгуулсан байдал зэрэг ухаалаг дэлгэц ашиглан зохион байгуулсан арга хэмжээний тайланг улирал бүр Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэст ирүүлнэ.

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир,
спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 18 ны
өдрийн 199 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

УХААЛАГ ДЭЛГЭЦ АВАХ АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГ, БАЙГУУЛЛАГА

№	Байгууллага	Нэмэлт санхүүжилтийн дансанд
1	ЗГТА-БТСУХороо	100900008433
2	Архангай аймгийн Биеийн тамир, спортын газар	100010035401
3	Баян-Өлгий аймгийн Биеийн тамир, спортын газар	100020035401
4	Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар	100030035401
5	Булган аймгийн Биеийн тамир, спортын газар	100040035401
6	Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газар	100050035401
7	Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газар	100220035401
8	Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газар	100190035402
9	Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар	100060035401
10	Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газар	100070035404
11	Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газар	100080035401
12	Завхан аймгийн Биеийн тамир, спортын газар	100090035401
13	Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар	100210035401
14	Өвөрхангай аймгийн Биеийн тамир, спортын газар	100100035401
15	Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар	100110035401
16	Сүхбаатар аймгийн Биеийн тамир, спортын газар	100120035402
17	Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар	100130035401
18	Төв аймгийн Биеийн тамир, спортын газар	100140035401
19	Увс аймгийн Биеийн тамир, спортын газар	100150035401
20	Ховд аймгийн Биеийн тамир, спортын газар	100160035401
21	Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газар	100170035404
22	Хэнтий аймгийн Биеийн тамир, спортын газар	100180035403
23	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	100200035401
24	Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200235401
25	Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200835402
26	Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200535401
27	Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200335401
28	Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200435401
29	Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200935401
30	Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200635401
31	Хан-уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200135401
32	Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо	100200735401
33	Техник спортын төв ТӨҮГазар	5622364171 /хаан/
34	Булган аймгийн Хангал сумын спорт бэлтгэлийн төв	4005131920 /голомт/
35	Биеийн тамир, спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төв	

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир,
спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 18 ны
өдрийн 119 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Ухаалаг самбар C65FA" inch (1522x931mm) & 1 dongle & 2 pen & keyboard mouse Low Parallax Anti-glare 12MP Camera Auto framing 8-metre voice pickup*4K UHD display High-Precision IR touch technology 2.1 stereo sound 40W High-Power speakerOnly Android system	35	9 090 000	318 150 000
2	Дугуйтай хөл /North Bayou AVA1800- Mobile stand: for 658 Dimension /W*D*H/: 1710*720*150 mm Gross Weight /Kg/:45	35	900 000	31 500 000
3	MAXHUB, OPS PC, MT51 - i5 8400, DDR4 8G/128SSD Core HD Grapics, 2 x USB3.0 ports, 1 x USB 2.0 ports, 1 x USB Type C, 1 x HDMI, 1 x mic in, 1 x Line Out, windows10 enterprise version included	35	2 410 000	84 350 000
4	Гар утасны дүрс тогтворжуулагчтай гимбал / гар утсаар лайв хийх/	35	480 000	16 800 000
5	Утасгүй интернэтийн төхөөрөмж	35	240 000	8 400 000
	Нийт дүн		13 120 000	459.200.000

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Д.АРИУНСАНАА

БОЛОВСРУУЛСАН:

БТБХХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

С.ХИШИГТХҮҮ